

ҮҮЛЭН ӨМНӨХ ОРНЫ МОНГОЛ УГСААТАН БУЮУ ЮНЬНАН-Ы МОНГОЛЧУУДЫГ НҮДЭЭР ҮЗСЭН МИНЬ

*С.Дашцэвэл**

Дэлхийд Юньнан-ы монголчууд хэмээн алдаршсан монгол угсаатантай уулзан учрах завшаан олдсондоо нэн олзуурхнам. Юньнань буюу утгачилбал “Үүлэн өмнөх нутаг” хэмээх муж Хятадын баруун урд хормойд Бирм, Лаос, Вьетнамтай хиллэн оршино.

Юньнан-ы монголчууд тус мужийн төв Куньмин хотоос өмнө зүгт 120 км орчим зайд Тунхай хошууны Чилуху нуурын хөвөө, Фенхуан уулын баруун бэлээр аж төрөн сууна. Орон нутагтаа Тунхайн монголчууд хэмээх нэрээр овоглосон эдгээр хүмүүс одоогоос 750 гаруй жилийн тэртээ буюу Мөнх хааны үед энэ нутагт очжээ. Түүхийн сурвалжаас үзвэл XIII зууны дундуур Монголын эзэнт гүрний их хаан Мөнх Өмнөд Сүн улсыг номхтгохын тулд түүний баруун өмнөд хязгаар дахь Юньнан-ы газар буюу тэр үеийн Дали улсад өөрийн дүү Хубилайгаар удирдуулсан арван түмэн цэргийг оруулж эзлэн суусны дараа Хубилайг Сычуаны зүг буцааж Урианхадай жанжинаар удирдуулсан нэг хэсэг монгол цэргийг үлдээсэн байна. Урианхадай жанжин Дали орныг сахин үлдэхдээ зах хязгаарын олон овог ястаныг номхтгож байр сууриа улам бэхжүүлжээ. Хубилай хаан ор суусны дараа Дали буюу Юньнан-ыг Эзэнт гүрний өмнөд хилийн муж болгож түмт, мянгат, зуутын засаг захиргааны нэгжид хуваарилан олон монгол захирагчийг ээлж дараалан суулгаж байв. Энд захиран суусан монголчуудын ноёрхол 1253 оноос эхэлж Юан улс мөхснөөс арав гаруй жилийн дараа буюу 1381 онд Мин улсын 30 түмэн цэргийн хүчинд арга буюу дийлэгдэн бууж өгсөн түүхтэй. Одоогийн Юньнань мужийн Тунхай хошуунд сууж байгаа монголчууд бол тэр нутгийг захиран сууж байсан монгол язгууртан цэргийн эрхтэн, тэдний ар гэр хамжлага албат нараас үлдэж хоцорсон нь тэр юм.

Ер Юньнань мужид тархсан монгол гаралтай хүмүүсийн тоог гаргавал хорь гучин түмээс наашгүй хэмээн судлаачид үзсээр байна. Учир нь Минь улсын цэрэг хүрч очих үед өмнөд хятадын нийт нутгаар байсан монгол цэргийн хүч ухран Юньнань-д цугларч байтал Куньмин-ий ойролцоох их тулаанд монголчууд бут цохигдон тэр хавийн уул тайгаар тархан цугтаад хожим нь нутгийн бага ястануудын овгийг авч нуугдан суурьшсан түүхтэй.

Тэртээ зүүн өмнө зүгийн халуун дулаан оронд хувь заяаны эрхээр орхигдсон эдгээр монгол удмынханы нутагт 1994 оны аргын улиралын өвлийн адаг сарын шинэдээр миний бие анх очиж Юньнаны

* С.Дашцэвэл - ОУСХ-ийн эрдэм шинжилгээний ахлах ажилтан, доктор (Ph.D), дэд профессор

монголчуудтай нүүр тулан танилцах сайхан боломж тохиосон билээ. Түүнээс хойш арван таван жил өнгөрчээ. Тэр үеийнхээ тэмдэглэлийг эргэн харвал “Өмнө зүгийн монгол элэгтэй монгол удмынхан минь баяртай. Өвөг дээдсийн нутгийнханд чинь та нарын халуун мэндийг дамжуулж, та нарыгаа танилцуулах нэгэн үзүүрт сэтгэл өвөрлөн буцлаа” хэмээн бичжээ. Өөр нэг хуудсанд “Эдгээр монголчуудын үүх түүх зан заншлыг ер юм болгоныг мэдэхийг хүсэвч цаг бага учир саваагүй их хүслийнхээ жолоог арга буюу татаж аялалаа товчиллоо. Гэвч дахин ирнээ. Туурга тусгаар монгол түмнийхээ халуун мэндтэй хамт ирнэ...” гэхчлэн бичсэн байлаа. Гэвч энд бичсэн хоёр амлалтаа ажил амьдралын эрхээр хойш тавьсаар өнөөг хүрсэн байлаа.

Саяхан миний бие Вьетнам улсад ажлаар очоод буцах замдаа ам алдвал барьж болдоггүй хэмээх монгол үгээ санан байж тус улсын баруун хойт чиглэлийн галт тэргэнд суун Лаокай хэмээх боомтоор гарч тэндээс өмнөд хятадын хот хоорондын унаанд сууж халуун дулаан орны өндөр сүрлэг уулсыг хярлан гүн хавцлыг эмжин өтгөн мананг сүвлэн өдөржин давхисаар далайн түвшинээс 2000-аад метрийн өндөрт орших Куньмин хотод хүрэв.

Куньмин хот бол Хятадын Юннань мужийн төв билээ. Юан улсын үед Венецийн худалдаачин Марко Поло энэ хотыг үзээд “Хот нь том, үйлдвэрлэл худалдаа үлэмж, буудай тариа элбэг” гэсэн байдаг. Өнгөрсөн зууны тавиад онд их бичгийн хүн Б.Ринчен гуай Энэтхэг явах замдаа Кунмин-д нэгэнтээ газардаж гудамж зээлийг нь ажиглан “...хотын байдал манай есөн гудамж, хуучин хүрээний Наймаа хот адил байшин барилга нь нэлээд хуучирсан байдалтай. Гудамжийн хоёр талаар үргэлжилсэн жижиг жижиг лангуугаар шагайн үзхэд гуталчин, үйлчин, багаахан гуанз, аар саар юмны худалдаа, айлын сууц мэт бөгөөд цахилгаан гэрэл тавиагүй тэр гудамжинд голдуу лаа барьжээ” хэмээн бичсэн байдаг.

Гэтэл эдүгээ Куньмин хот эрчимтэй хөгжиж байгаа хятад орны нүүр царайг илтгэсэн орчин үеийн томоохон хотуудын нэг болжээ. Энэ хот арван таван жилийн өмнө миний очсоноос хойш богино хугацаанд их өөрчлөгдөж, шил толь болсон олон сайхан барилга байшин сүндэрлэн босчээ. Хотын дунд цахлай цуглан толгой шүргэн алдаж нисээд барьж байгаа талх тариаг шүүрэн авдаг үзэсгэлэнт нуурыг дахин үзэхээр зүглэсэн боловч олсонгүй. Бодвол цахлай нь олны хөлөөс дайжин алга болсон бизээ. Юан гүрний эхэн үед Юннань-д сууж агсан уйгур захирагч Сайд Ад-дин Чүйн нэрээр нэрийдсэн нэгэн томоохон нуур хотын баруун захад байх бөгөөд монгол захирагч нар тэр нуураас суваг татуулж цэргүүдээр атар хагалуулан амуу тариалж байсан түүхтэй билээ. Мөн Юан улсын Өлзийт Төмөр хааны I он буюу 1295 онд монголын элч нартай хамт Комбож улсад очиж “Комбожийн зан

заншлын тэмдэглэл” хэмээх ном бичиж үлдээсэн, тэр ном нь эдүгээ комбож үндэстний түүх соёлын судалгаанд чухал хэрэглэгдэхүүн болсоор байгаа түүхэн хүн Чу Дагуан-ы нэрээр нэрлэгдсэн том зээлийн газар хотын төвд байх. Энэ мэт монголын эзэнт гүрний түүхтэй холбоотой эртний дурсгал олонтой Куньмин хотын Үндэстний Дээд сургууль дээр очвол “Үндэстний соёлын ялгаа ба хөгжил хүмүүнлиг”-ийн асуудлаар ном хаялцах олон улсын ээлжит Чуулган болохоор хөл ихтэй байв. Тус сургуульд урьд очиж эрдмийн хүрээлэнгээр нь орж байсан удаатай тул энэ удаа өөрийн хүрээлэнгийн албан бичигтэй байсан боловч их ажлын нь дундуур төвөг удахыг эс төвдөж шуудхан Юньнан-ы монголчууд руу очихоор шийдэв.

Куньмин хотод суугаа Вьетнам улсын Консулын газарт Монгол Улсын Их сургууль төгссөн Тхюй хэмээх эмэгтэй гэр бүлийн хамт ажиллаж байгаа тул түүн рүү утас цохиж монгол тосгон руу явах хөлсний унаа болон сайн хэлмэрчийг олж өгөхийг хүссэнд алтан гинж алтан бөгж зүүсэн тавь эргэм насны зузаан бор хүнийг авчран танилцуулав. Тэр хүн вьетнам гаралтай бөгөөд Юньнан-ы монголчуудаас нэгэн бүсгүйг гэргий болгон суусан нэг ёсондоо Юньнан-ы монголчуудын хүргэн хүн аж. Тэр хүн халмуудаа амьд сэрүүн байх үед монгол тосгонд байнга очдог байснаа ойрд очоогүй хэмээн ярьж байв. Энэ удаа хамт явах боломжгүйдээ харамсч уучлал гуйгаад өөр хүн олж туслуулав. Ийнхүү өглөөний есөн цагийн алдад Куньмин хотоос өмнө зүгийг чиглэн довтолгов.

Шинэхэн тавьсан өргөн цардмал замын дагуу үржил шимт мөнх ногоон толгод үргэлжилж, түүний дээгүүр элдэв төрлийн жимсний таримал үелэн харагдана. Саяхан Вьетнамын дөчин хэмийн халуунд сэрүүцүүлэх сэнс амь мэт хэрэг болж байсан бол энд түүнийг ор тас мартав. Далайн түвшнээс 2000-аад метр өргөгдсөн энэ нутгийг эртнээс сэр сэр салхитай бүр бүр хуртай өвөлгүй зунаар байдаг бурхан бумбын орон гэдэг нь чухам л үнэн бололтой. Эзэнт гүрний үед монголчууд түүнийг мэдээд бүх хятадыг эзлэхээс бүр 20 гаруй жилийн өмнө энэ нутагт эзэн суусан ч юм бил үү. Эрт цагт энд бирм, тай овог хэлтний өвөг дээдэс Наньчао хожим нь Дали гэх хүчирхэг вант улсыг байгуулан олон зуун жил туурга тусгаар оршин тогтнож байсан удаатай. Түүнийг Хубилай хаан өөрийн эзэнт гүрний нэг хэсэг болгосноор хожим хятадын салшгүй хэсэг болох замыг нь шулуутгажээ.

Замын дагуу үе үе шинэхэн хот суурин үйлдвэрийн газар үргэлжилсээр нэг мэдэхэд монгол тосгонд хүрч очив. Юньнан мужийн Тунхай хошуун дахь монгол үндэстний өөртөө засах тосгоны захирагч намхан бор залуу, түүний соёл мэдээлэл хариуцсан эмэгтэй нар биднийг хүлээн авч монгол үндэстнийхээ тухай танилцуулав. Фенхуан буюу монголоор Хан гарьд хэмээх уулын баруун хормойг түшсэн таван

тосгонд өөр үндэстний хүн гурав хүрэхгүй хувь байдаг гэнэ. Тэдний ихэнх нь өөр нутгаас буулгасан бэр бөгөөд монгол үндэсний хувцас өмсч тосгоны зан заншлыг дагадаг ажээ.

Эндэхийн монголчууд өнгөрсөн түүхийн урт хугацаанд ялангуяа Мин улсын эхэн үед толгой дараалан хядуулж нуугдах зугатахын түмэн зовлон амсаж гагцхүү Чин улсын сүүлчийн жилүүд болон иргэн улсын үед сая амар жимэр аж төрөн суух болсон гэнэ. 1987 онд монгол үндэстний өөртөө засах “Шинэ монгол” тосгон хэмээх засаг захигааны нэгж болгожээ. Сүүлийн үед Юньнан-ы олон ястаны хүмүүсийн дотор гэрийн бичиг, овгийн хөшөө дурсгалын зүйлээс өөрсдийгөө монгол үндэстэн гэдгийг олж мэдэх нь олширч байгаа аж.

Тунхайн монголчууд урьд зөвхөн газар тариалан загасны аж ахуй эрхэлж байсан бол зах зээлд шилжсэнээс хойш айл өрхүүд нь олон төрлийн аж ахуй эрхэлдэг болжээ. Өрх бүр тариалангийн талбайтай. Төрөл бүрийн жимс, нишингэ, тутрага, цайны болон тамхины ургамал түлхүү тариалж байгаа нь орон нутгийн байгаль цаг уурын нөхцөлд тохирсоноос гадна зах зээлийн эрэлт хэрэгцээтэй холбоотой гэнэ. Ер энэ мужийн тамхины үйлдвэрлэл хятад даяар алдартай бөгөөд хамгийн сайн тамхи нь энэ нутгийнх ажээ. Усан үзмийн аж ахуй, тоор жимсний аж ахуй ихэд хөгжсөн гэнэ. Юан улсын үед энэ нутгийг захирч байсан Хубилайн удам Алугтөмөр гэгч цэрэг ардыг захирах засаг захиргааны томоохон суурин байгуулж мянган суурь тоорын мод суулган анх тоорын цэцэрлэг байгуулж байснаас үүдэн энэ нутагт тоор жимс /персик/ тариалах ажил дэлгэрсэн түүхтэй юм байна. Монгол тосгонд гадаад дотоодын жуулчид сүүлийн үед ирэх болсон тул аялал жуулчлалын салбарыг нэлээд анхаарч байна. Аялал жуулчлалын ажлыг хариуцсан эмэгтэй биднийг дагуулж тосгоны зарим газраар оруулав. Ийнхүү үйлчлэхдээ хүн бүрээс дөчин юаны хураамж авдаг журамтай боловч биднээс авсангүй.

Тосгоны байшин барилга нэн шигүү бөгөөд эртний хотын хэрэм балгас шиг өндөр ханатай юм. Тэдгээр өндөр байшингийн нарийн гудамжаар чулуун шал дэвсэн зам зассан байх ажээ. Тосгоны дунд шавар хэрэм мэт цонхгүй өндөр байшин үе үе тааралдах бөгөөд түүнд тамхины ургамалын том далбагар навчийг багцлан дүүжилж доороос нь угаж хатаадаг гэнэ. Тосгоны дунд нэгэн жижиг дуган байх бөгөөд “Дээдсийн (Чингисийн) шүтээний сүм” нэртэй ажээ. Харамсалтай нь энэ удаа засвартай тул орж чадсангүй. Гадна талд нь боржин чулуугаар зам тавьж тохижуулах ажлыг ид хийж байв. Энэ сүмийн хойморт Чингис, Мөнх, Хубилай гурван хааныг онголон тахиж бурхан лугаа хүндэтгэн хүж зул асаан мөргөл залбирал үйлддэг заншилтайг тэр жил үзэж зураг хөргий нь авч байсан удаатай. Энэ удаа ч цоожтой хаалганы нь завсраар шагайж зургий нь авав. Гурван хааны хажууд хэд хэдэн

чулуун хөшөө байх бөгөөд түүний хамгийн том нь Юньнан-ы монголчуудын дээд өвөг Алугтөмөрийн бунханы хөшөө байв. Нэг метр гаруй өндөртэй хөх чулуун хөшөөний дээр улаан зосоор тодотгосон нанхиад бичээс харагдана. Түүний дэргэд Алугтөмөрийн хөвүүн Зандан юаншуайн дурсгалын хөшөө байх бөгөөд эдгээр хөшөөг өнгөрсөн зууны 70-аад онд нутгийн нэгэн өндөр уулын хяраас олж авчраад байрлуулсан нь энэ ажээ. Эдгээр монгол захирагч Юан улсын Тогоонтөмөр хааны үед тус газар оронд ирээд их зүйл хийж сургууль байгуулан, сүм хийдийг босгож ард олныг амгалан тайвнаар захиран суусан учир нутгийнхан их л хүндэтгэж байсан аж. Тэднийг Юньнан-ы монголчууд өөрсдийн дээд өвөг гэх учир голдуу Зан овогтой болжээ. Тосгоны хойт захад орших бас нэгэн сүмд оров. Түүний дуганч ная гаруй насны буурал эмээ олон түлхүүр шажигнуулан байж хаалгыг онгойлгов. Дотор нь бурханы бодисатва нартай зэрэгцэн монгол ташуу энгэртэй хувцас нөмрөг бүхий хэд хэдэн хүний суумал баримал харагдана. Учрыг асуувал манж чин улсын үед нутаг орон үндэс угсаагаа хамгаалан тэмцсэн гавъяатай өвөг дээдсээ шүтэж босгосон сүм гэнэ. Манж чин улсын үед ийм үйлдэл хориотой байсан тул бурханы сүмээр халхавч хийн шүтэж иржээ. Зүүн өмнөд Ази даяар ийм сүмд голдуу хүж лаа асаах заншилтай. Гэтэл энэ сүмд цөгцтэй зул асаасан байх нь их л содон харагдав. Дуганч эмээ бүхий л насаар энэ дуган сүмийг сахиж байгаа гэнэ. Эмээгийн урд үеийн өвөг энэ барималыг бүтээж сүмийг босголцсон ажээ. Эмээтэй олон зүйлийг асууж хөөрөлдөх гэсэн боловч нутгийн хэлээр ярих тул бид ойлголцсонгүй. Нутгийн хэл гэдэг нь ий, бай үндэстэн, эртний монгол гурван хэлний дундаас гарсан холимог хэл ажээ. Үгийн сангийн гуч орчим хувь нь монгол үг байдаг гэлцэнэ. Заримаас дурдвал: Набуча (чих), ицигэ (толгой), тучиса (хувцас), накмай (хамар), ниати (нүд) гэх мэт. Өвөг дээдэс нь монгол бичиг бүхий зарим ном судар хадгалж байсан сураг мэдээ байвч одоо нэгэнт оргүй болсон ажээ. Харин хожим нь монгол үгийг хятад үсгээр галиглан бичиж байсан, бас заримдаа хятад монгол үгийг холилдуулан бичиж байсан баримт байх юм. Тухайлбал Юньнан-ы нэг түмтийг захирч байсан монгол вангийн охин Агай гүнж “Гуниг ундууцлын шүлэг” хэмээх зохиолоо тийнхүү хятад монгол хэлээр холилдуулан бичиж үлдээсэн байх аж.

Эндэхийн монгол үндэстний нэг онцлог нь монгол хэлээ мартсан боловч түүхээ маш сайн мэддэг, түүнийгээ үр хойчисдоо заавал үлгэр адил ярьж уламжлуулдаг заншилтай гэнэ.

Тэд олон зуун жил энэ нутагт аж төрөн суухдаа нутгийн уугуул ий, бай үндэстний зан заншлаас нэлээд зүйлийг авчээ. Байгаль цаг уурын нөхцөл, эрхэлж буй аж ахуй хэрэглэж буй хоол унднаас шалтгаалан тэдний төрх, зүс царай өмнөд хятад, бирм, лаосын бага

ястан лугаа адил мэт боловч бас ч монголжуу шинж төлөв тод ажиглагдана. Тэдний дунд монголжуу өргөн шанаатай, онигордуу нүдтэй хүмүүс нилээд байна. Өмнөд хятадынхан ихэнхдээ хамар охор, чих жижиг байдаг билээ. Гэтэл монгол удмынхан дотор чихний омог гонзгойдуу, хамар уртлаг байх нь олонтаа байна.

Хувцас нь нутгийн ий ястаны хувцастай нилээд төстэй боловч өөрийн гэсэн онцлогтой ажээ. Тэд зах зээлийн газар олон хүний дундаас хурц тод өнгийн хувцсаараа онцгой ялгаран харагдах учир нутгийнхан монголчууд гэж төвөггүй таних юм. Ялангуяа монгол эмэгтэйчүүд хурц улаан, тод ногоон, цагаан цэнхэр өнгийн хошмогтой ханцуй углаж хэд хэдэн давхар богино хантааз өмсөх бөгөөд алчуур нь заавал тод улаан өнгөтэй байх юм. Заримдаа хар бараан алчуур зангидвал дундуур нь улаан өнгийн тууз заавал байх жишээтэй. Энэ нь улаан залаат монголчуудын удам гэдгийг илтгээд байх шиг. Алчуураа дээш шовойлгон өндөрлөж бооно. Нөхөрт гарсан бүх эмэгтэй ингэж үсээ дээш шомбойлгон өндөр шовгор болгодог заншилтай. Эртний монголчуудын насанд хүрсэн эмэгтэй богтого малгай өмсдөг заншлын улбааг ийнхүү хадгалсаар байна. Ер нь богтого малгай гэдэг нь (үсээ) боодог малгай ч гэсэн утгатай байж магадгүй билээ. Тэдний өргөн хэрэглэж эрхэмлэдэг өнгийг асуувал тод ногоон, хөх, улаан өнгө байна. 50-иад оноос өмнө урт дээл, түрийтэй гутал, бүс хааяа үзэгддэг байсан гэнэ. Зургийн гуунд нь өвөг дээдсийн нь зураг байх бөгөөд тэд монгол ташуу энгэртэй дээлтэй байв. Харин эрэгтэйчүүдийн хувцсанд ялгагдах онцлог гэх юм алга.

Зан төрх нь их л монголжуу хээ шаагүй, гүдэс шулуун, гүндүүгүй цагаан, аливаа зүйлд ёсорхох юм алга. Идэж уух нь хятад хүмүүсээс арай л элбэг бийлэгжүү загнах жишээтэй. Арвилж хэмнэх талаар ч гэсэн бидэнтэйгээ адил хамаагүй болов уу гэж бодогдоно. Махан хоол бусдаас илүү хэрэглэх бололтой. Тосгоны гуанзанд монгол хүмүүсийн идэж буйг ажиглавал махан хоол зонхилно. Биднийг монголоос очсон болохоор ч тэр үү, бүр ч их махан хоолоор дайлав. Монгол удмынхан дуу хууранд дуртай нь илт байв. Цайллаган дээр өвөрлөгчийн нэрмэл архийг хундагалаад монгол дуу хэмээн нэгэн дуу дуулшгаав. Яг л монгол ардын дуурхуу урт уянгалсан аятай байв. Өөрсдийгөө Монла гэж нэрлэх нь сонсогдоно. Хятадууд харин тэднийг Мэнзу хэмээх нь монгол үндэстэн гэсэн үг ажээ. Энэ нутгийн адуу, тэрэгний морь арай биерхүү байгаа нь монгол адууны удам гэлтэй. Моринд дуртай монгол хүн л болсон хойно эмээл хазаарыг нь ажиглав. Хазаар нь монгол хазаартай төстэй юм.

XIII зууны үед энэ нутагт анх монгол цэргүүд ирж суурьшихдаа адуу малын сайхан бэлчээр гэж сонгосон нь хожим тариа ногооны үржил шимтэй нэгэн өлгий болжээ. Куньмин хотоос шулуухан ирсэн өргөн цардмал замыг дагаад сүүлийн арваад жил бум бужигнаж түм түжигнэсэн шуугиант хот суурингууд бий болж монгол тосгоны яг

хаяанд тулжээ. Орчин үеийн хотжилт иргэншилтэй зэрэгцэн их хятад үндэстний давалгаа монгол тосгоныг үерийн ус мэт юу юугүй нөмрөн авсан харагдана.

Бид буцах цаг болж монгол тосгоноос мордов. Куньмин хотын зүг суудлын тэрэг хурдаа аван арав хүрэхгүй км яваад нэгэн хөтөл дээр гартал тэр жилийн миний очсон ухаа нуруу дүнхийж харагдана. Түүнийг монголчууд “Хөтөл боомт” гэх бөгөөд XIII зуунд монгол захиргааны цэрэг ардыг захирах томоохон суурин байсан газар билээ. Энэ удаа тэнд очих цаг хугацаа олдсонгүй. Гэвч 1994 онд Хөтөл боомтод очих сайхан боломж тохиосноо дурдахгүй өнгөрч боломгүй нь.

Монгол тосгонд засаг дарга хийж байгаад тэтгэвртээ суусан ахимаг насны нэгэн сайхан өндөр бор хүн тэр өдөр ар монголоос ирсэн миний сургаар Тунхай хошууны төвөөс хятад 69 машин хөлөглөн зориуд давхиж ирэн танилцаж тэр даруй намайг дагуулан “Хөтөл боомтод” очиж билээ. Монгол дарга уул өгсөн давхиж даваан дээр гарч тэргээ зогсоогоод “Энэ даваагаар монголын морин цэргүүд анх давж ирсэн юм. Хөтөл боомтын морин даваа нэртэй энэ замаар морин тэрэгтэй, тэрэггүй хүмүүс давсаар их тод зам байсан юм, энэ доод бэлд түмтийн ордон, тээр тэр толгойн өвөрт мянгатын суурин байсан юм” хэмээн яг л өчигдөрийн юм шиг танилцуулж, “эндхийн тоорын цэцэрлэгийн ор суурь их тод байсан боловч хөрс шороо нь их үржил шимтэй учир хүмүүс худалдан аваад тариа тарьчихсан юмаа” гэж байв. Яг тэр хөтөлийн ар луу бууж нэгэн худгийг зааж “Энэ худгийг анх монголчууд гаргасан юм” гэв. Худгийн дэргэд дөрөв таван охид хүүхдүүд юм угааж байв. Худгийн дээр цементэн хамгаалалт барьсан нь нэн эртнийх бололтой. Чулуун ханан дээр нь Чин улсын үед бичсэн бичээс нэн бүдгэрсэн харагдана. Морин даваанаас доош бууж 4.5 км явтал нэгэн суварга тааралдав. Түүнийг Азала хэмээх монгол захирагчийн дурсгалд зориулсан суварга хэмээн тайлбарлав. Азалагийн суваргын тэр хавьд хятад хүмүүс суурьшиж, суваргын агуулга хятадын суварга мэт болж нэр нь хүртэл өөр болсон ажээ. Ийнхүү сонин сайхан зүйлийг бүтэн өдөр үзүүлэн сонирхуулж монгол тосгонд буцаан авчирсан тэр ачит хүнтэйгээ уулзахаар сураг тавьсан боловч олдсонгүй. Тэр үед олон сайхан юм тэр хүнээс сонсч мэдмээр бас монголчуудынхаа тухай ихийг хэлж танилцуулмаар байсан боловч хятад хэлийг нарийн сайн сураагүйдээ тун ч их харамсч билээ. Хашир хүн гэж хаширсан хүнийг хэлдэг гэгчээр энэ удаа дутагдлаа давтахгүйн тулд тусгай хэлмэрч хөлсөлж бас дээр нь орчин үеийн монгол нутгаа танилцуулсан баримтат кино, зурагт альбом, монголын хөдөө нутгийн байгаль ахуйг дүрсэлсэн тосон будгийн жаазтай зураг, бас бус зүйлийг монгол тосгоныхонд зориулан авч очсон билээ. Түүнийгээ Монголын Энх тайван найрамдлын төлөө Холбооны нэрийн өмнөөс гардуулан

бас ч олон жилийн өмнөх амлалтаа биелүүлж чадсандаа санаа амарч сэтгэл өегшин буцаж яваа нь энэ.

Буцах замдаа бид Куньмин хотын баруунтаа дүнхийх Юй Аншан уулын баргашин замаар өгсөж Чиюн Зү хэмээх сүмд очив. Гол зорилго нь тэр сүмийн дотор байгаа Юан улсын үеийн монголын гэрэлт хөшөөг үзэх явдал байлаа. Сүмийн үүдэнд очиж монгол хөшөө хаана байгааг лавлавал гурван хаалганы цаад гол сүмийн хананд буй хэмээн зааж өгөв. Сүмийн үүдэнд Богдын ногоон сүмийн үүдэнд байдаг шиг найман тохой хирийн өндөртэй дөрвөн махранз сүртэйгээ зогсоно. Түүний дотор талын хананд таван зуун найдангийн уран нарийн хийцтэй барималууд хана даган ярайж харагдана. Манай Чойжин ламын сүмийнх шиг найдан болгон өөр өөрийн араншинг илтгэх мэт янз янзын дүртэй ажээ. Дээш өгсөн голын сүмд орвол сүрлэг том гуулин бурхад алтан шаргал өнгөө гялалзуулан залрах ажээ. Энэ сүмийн баруун хатавчины хананд монгол хөшөө маань харагдав. Хятад үсэгтэй тал нь гадагш харж монгол үсэгтэй тал нь сүмийн дотор талд байх тул хэн хүнд тэр болгон харагдахааргүй юм. Бид гэрэл тусган харвал монгол үсэг тодоос тод жирийж харагдана. Монгол үсгээ хараад танил хүнтэйгээ уулзах мэт сэтгэл гийж янз янзаар зургийг нь авав. Хөшөөний дээд хэсэгт Пагва ламын дөрвөлжин үсгээр бичсэн бичээс харагдана. Энэ бол Юан улсын Янь Ю-гийн гуравдугаар он буюу Буянт хааны үед (1316 онд) босгосон Аруг вангийн гэрэлт хөшөө билээ. Өнгөрсөн зууны эхээр Юньнан-ы наси үндэстний нэгэн профессор энэ хөшөөг анх олж дээр нь сийлсэн бичээсийг хуулбарлан Францын монголч эрдэмтэн Павел Пелиод дамжуулснаар дэлхийн монголч эрдэмтдийн сонорт хүрч, хожим нь монголын хэл бичгийн эрдэмтэн Х.Лувсанбалдан мөн судлан нийтийн хүртээл болгосон түүхтэй. Аруг ван бол Юан улсын үед Юньнан-ыг захирч байхдаа эртний Тан улсын үеийн энэ сүмд очиж хувиасаа түмэн лан цагаан мөнгө хандивлаж сэргээн босгоод шинээр тэргүүн хамбыг томилж олон ардыг “номын ёсоор зөөлтгөж цэргийн сүрээр номхтгож” байсан ван тул түүний гавьяаг дуртган энэ хөшөөг бүтээсэн аж.

Юннань их сургуулийн профессор Фан Лин Гүй гуай тэр жил намайг очиход амьд сэрүүн байсан бөгөөд Юан судлалын нэртэй том эрдэмтэн буурал билээ. Фан Лин Гүй профессор Куньмин хотоос баруун зүгт орших Дали-д Хубилай хааны 3 метр гаруй өндөр 1,7 м өргөн 0,5 м өргөн аврага том гэрэлт хөшөө буй. “Шизу хаан Юннаныг төвшитгөсөн хөшөө” нэртэй олон зуун үсэгтэй энэ хөшөөг Манж Чин улсын үед босгосон юм. Энэ гэрэлт хөшөөнөөс нутгийн хүмүүс адис аван гар хүрч бас ходоод гэдсэнд сайн гэлцэн холтолж чанаж уусаар элэгдэн хуучирч байгаа хэмээн харамсан өгүүлж байв. Монголын түүхийг хар багаасаа сонирхож эхэлсэн энэ өвгөн профессор 1991 онд хэвлүүлсэн “Юан, Мин улсын үеийн драмын жүжигт байгаа монгол

үг хэвлэг” гэсэн томоохон бүтээл дээрээ гарын үсгээ нямбайлан зурж бэлэглэж билээ. Энэ профессор Юннань муж дахь Юан улсын үеийн монголчуудын үлдээсэн олон хөшөө дурсгалыг хамгаалж нийтлэн, дэлхийн олон эрдэмтний хүртээл болгоход их тус хүргэсэн байна. Хүндэтгэмээр энэ сайхан буурал эрдэмтэн салахын өмнө хэлэхдээ “эцэст нь би танд өөрийнхөө намтрыг хэлэхэд би чинь хагас монгол, хагас хятад хүн шүү. Миний эх Горлос овгийн монгол хүн” гэж хэлж билээ. Тэр хүн уг нь Ляонин мужийн хүн ажээ. Хятад нутгийн хамгийн өмнөд үзүүрт Лаос, Бирмийн хилээс холгүй энэ нутагт монгол цустай нэгэн том эрдэмтэн байгаад сэтгэл минь хөдөлж бахархах сэтгэл төрж билээ.

Халуун дулаан өмнийн нутагт тасарч хоцорсон эдгээр монгол элэгтэн, монгол удмынхан алс холоос биднийгээ дурсан, чих тавин чагнаж бас бахархан суудаг ажээ. Ээ дээ, энэ дэлхийн цөөхөн монгол бие биенээ эрхэмлэн дээдэлж хаана ч явсан өвөг дээдсийн үед хүй нэгтэй байснаа мартаж өсгүй. Монгол овогтон бид энэ цагт бие биенээ дэмжин тэтгэж өөдлөх учиртай хэмээн аян замын тэмдэглэлээ төгсгөө.

Куньмин-Улаанбаатар, 2009 оны 8 сарын 22